



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.18 № 493

танай 2024.07.17 -ны № 01/61 -т

ХЭРЛЭН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД  
АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА У.ДАШ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Дорнод аймгийн Хэрлэн сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011021351

## Дүгнэлт

Хэрлэн сумын Ардчилсан намын хорооны Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дорнод аймгийн Хэрлэн сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (8 хуудас)-ыг хавсаргав.

Хувийг: Хэрлэн сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 8 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2024 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН АРДЧИЛСАН НАМААС  
ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.07.17

Хэрлэн сум


Нэр: ШИНЭ ЧОЙБАЛСАН

Уриа: "ЗОРИГТОЙ ӨӨРЧИЛБЭР"

**Зорилго:** Улс, орон нутгийн эрх ашиг, хуулийг дээдлэн, хувь хүн, өрх гэр, сум, аймаг, бүсчилсэн хөгжлийг эрхэмлэж баялгийг бүтээгч иргэдийн амьдрах аюулгүй ая тухтай амьдрах нөхцлийг хангах, дундаж орлоготой иргэдийг нэмэгдүүлж, Чойбалсан хотын шинэ бүтээн байгуулалт, эрчимтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

Хүрээлэн буй орчин нь тааламжтай, амьдралын чанараа тогтмол дээшлүүлэх нөхцөл бүрдсэн хотод эрүүл, боловсролтой, ирээдүйдээ урам зоригтой амьдрах боломжийг цогцлоох нь Хэрлэн сумын мөрийн хөтөлбөрийн хөгжлийн бодлогын зорилт байна.

Бүхий л бодлогын цөмд ИРГЭН байна. Иргэнд ээлтэй орчин, Иргэнд өгөөжтэй эдийн засаг, Иргэнд хүртээмжтэй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, дэд бүтцийг бүрдүүлэхийн төлөө ажиллана.




Хэрэгжих хугацаа: 2024-2028

Зорилт:

1. АМГАЛАН, НАЙРСАГ ЧОЙБАЛСАН
2. АМЬЖИРГААТАЙ, ОРЛОГОТОЙ ЧОЙБАЛСАН
3. АЮУЛГҮЙ, НОГООН ЧОЙБАЛСАН
4. АЖИЛСАГ, БҮТЭЭЛЧ ЧОЙБАЛСАН
5. АВЛИГАГҮЙ, АРДЧИЛСАН ЧОЙБАЛСАН
6. АРД ИРГЭДДЭЭ ЭЭЛТЭЙ ЧОЙБАЛСАН

## НЭГ. АМГАЛАН, НАЙРСАГ ЧОЙБАЛСАН

- 1.1. Чойбалсан хотын иргэдийн санал санаачлагад тулгуурласан хүний аюулгүй, ая тухтай амгалан тайван амьдрахад чиглэсэн найрсаг, эрчимтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2. Аймгийн төвийн “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г шинэчлэн мөрдөж, төлөвлөлтгүй дур зоргын хөгжлийг таслан зогсоож гажуудлыг арилгана.
- 1.3. Чойбалсан хотыг улсын зэрэглэлтэй хот болгон өөрчилж зүүн бүсийн хөгжлийн төв болгоно.
- 1.4. Хэрлэн голын урд “Шинэ - Ногоон Чойбалсан” хотыг бий болгох төлөвлөлтийг эхлүүлж, хотын хөгжлийн болон иргэдийн шинэ амьдралын хэв маягийг бий болгоно.
- 1.5. Хотын хөдөлгөөн ихтэй газруудад төвийн шугаманд холбогдсон 00 хогийн сав, тамхи татах цэгийг ажиллуулж, зөв ашиглах хэрэглэх соёлыг олон нийтэд хэвшүүлж ажиллана.
- 1.6. Хэрлэн голын эрэг дагуу Хэрлэн орчмын аялал жуулчлалыг бодлогоор хэрэгжүүлнэ.
- 1.7. Гадаадын болон дотоодын аялагчдыг татах, “Найрсаг Чойбалсан”, “Морь”, “Талын малчин айл” зэрэг аялалуудыг боловсруулж брэнд аялал болгон хэрэгжүүлнэ.
- 1.8. Хот доторх түүхэн аялал жуулчлалын маршрутыг бий болгож, хотоороо бахархах, хайрлан хамгаалах үзлийг иргэн бүрт төлөвшүүлэх, гаднаас ирэх жуулчдын заавал үзэх хотын брэнд газрыг бий болгоно.
- 1.9. “Хотын соёл- мэндчилгээ инээмсэглэлээс эхэлнэ” нөлөөллийн сургалт үйл ажиллагааг бүх хүн амд зохион байгуулна.
- 1.10. Хотын өнгө загварыг анхны бий болгосон “европ стандарт”-аар хөгжүүлэх бодлогыг баримтлана.
- 1.11. Хотхон, байруудын дундах хүүхдийн тоглоомын талбайг шинэчлэн, хүүхдийг эрүүл чийрэг зөв хөгжүүлэх үүрэг бүхий тоглоом, элс, ус, ногоон байгууламжийг бүрдүүлж, бүх насны хүмүүсийн амрах орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллана.
- 1.12. Захын хэд хэдэн багуудад, иж бүрэн цогцолбор тоглоомын талбай байгуулна.
- 1.13. Чойбалсан хотод олон улсын соёл, урлаг спортын уралдаан тэмцээн наадам, эвентүүдийг зохион байгуулж, хөрш орнуудтайгаа найрсаг харилцаатай ажиллаж, шинэ сайн туршлагыг судалж, хэрэгжүүлнэ.
- 1.14. Байгууллага бүр, байгууллагын ой, бусад түүхэн ой, томоохон баяр наадмаар, хотын соёлд хувь нэмэр оруулах “нэг соёл-нэг ажил”-ыг санаачлан, өрсөлдөж ажиллах боломжийг бүрдүүлж өгнө.
- 1.15. Байгууллага, хамт олон, айл өрх, иргэн бүрийг “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжин мод бут тарих, ингэхдээ хотын соёлд өнгө үзэмж нэмэх, хашаа хайс болгон зохион байгуулалттай зөв тарих, арчлах, ургуулахад нь төрөл бүрийн үйл ажиллагаагаар дэмжин ажиллана
- 1.16. Хэрлэн сумын зарим гудамжийг явган хүнд зориулсан худалдаа, үйлчилгээний “авто машингүй гудамж” болгоно.




- 1.17. Дугуйн болон явган алхалтын замын сүлжээг нэмэгдүүлж, мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэнэ.
- 1.18. Жуулчдын очих гол цэгүүдэд хүрэх нийтийн тээврийн болон тусгай автобусны хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулна.
- 1.19. Хуучны байруудын өнгө үзэмжийг сайжруулж, гадна пассадыг үе шаттай хийнэ.

### **ХОЁР. АМЖИРГАА, ОРЛОГОТой ЧОЙБАЛСАН**

- 2.1. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 2.2. Мал мах, түүхий эд боловсруулах үйлдвэрийг бий болгож малчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.3. Байгалийн хадлан бэлтгэгчид, ногоон тэжээл тариалагчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4. Сумын хөгжлийн сан, жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэн иргэдэд ил тод, нээлттэй, шударгаар хуваарилж, иргэдийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.5. “Сумын хөрөнгө оруулалтын сан” хөтөлбөрийг хэрэгжүүлж малчин өрх, жижиг дунд бизнес, аж ахуй эрхлэгчдийг дэмжин орчин үеийн техник технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засгийн нөхцлийг бүрдүүлнэ
- 2.6. Төмс, хүнсний ногоо, сүү, өндөг болон импортоор оруулж ирдэг хүнсний бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэж иргэддээ хүргэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.7. Өрхийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж хуримтлалтай өрх, орлоготой иргэнийг төлөвшүүлнэ.
- 2.8. Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэж, өмчилсөн газраа барьцаалан санхүүгийн эх үүсвэртэй болох боломжийг бүрдүүлнэ.
- 2.9. Иргэн бүрийг өмчлөлийн газартай болгох ажлыг эрчимжүүлж, шинээр өмчлүүлж буй газрын төлөвлөлт, дэд бүтцийг шийдэх, хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт суулган шийдвэрлүүлнэ

### **ГУРАВ. АЮУЛГҮЙ, НОГООН ЧОЙБАЛСАН**

- 3.1. Чойбалсан хотын иргэдийн санал санаачилга, Аймгийн төв болон сумдын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г шинэчлэн мөрдөж, төлөвлөлтгүй дур зоргын хөгжлийг таслан зогсоож гажуудлыг арилгана.
- 3.2. Гэр хорооллын шороон болон сайжруулсан хайрган хучилттай замуудыг бүрэн гэрэлтүүлэг, явган хүний зам бүхий хатуу хучилттай болгоно.
- 3.3. Засмал зам, гэрэлтүүлэг, явган хүний зам, дугуйн зам, ногоон орчин бүхий “Цогц гудамж” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.4. Чойбалсан хотын гэрэлтүүлэг, ногоон байгууламж, тохилог орчныг эрс сайжруулан ногоон хөгжлийн баримжаа бүхий хот болгоно.



3.5. Хогны шинэ менежментийг нэвтрүүлж иргэдийг цэвэр цэмцгэр, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. Ингэхдээ хувийн хэвшлийн өрсөлдөж ажиллах боломжоор хангана.

3.6. Хогийн цэгт ангилан ялгалтыг хэрэгжүүлж хэвшүүлж ажиллана. Хатуу хог хаягдлыг дахин боловсруулах технологийг нэвтрүүлнэ.

3.7. Хогийн цэгийн байршлыг өөрчлөн, хог ангилан ялгах, дахивар худалдан авах ухаалаг төхөөрөмж бүхий цэгүүдийг бий болгох, дахин боловсруулах, үйлдвэрлэгчдэд буцаан борлуулах тогтолцоог бий болгоно.

3.8. Архигүй Дорнод хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.9. Архи согтууруулах ундааны хэрэглээгүй “Эрүүл идэвхитэй амьдралын клуб” үүсгэн ажиллах баг, хамт олныг дэмжин ажиллана.

3.10. Хотын ногоон байгууламжийг бий болгохдоо үрийн чанарт анхаарч, цэцэрлэг, ногоон байгууламж хариуцсан компаниудтай гэрээ байгуулж арчлалт, хамгаалалтыг хариуцуулан хамтран ажиллана.

3.11. СӨХ-ийн менежментийг боловсронгуй болгож, СӨХ, оршин суугчдыг нэг зүгт харж, амьдрах орчноо сайжруулах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.12. Хорт утаанаас урьдчилсан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.13. Чойбалсан хотын ундны цэвэр усны хангамж, аюулгүй байдал, цэвэршүүлэлтийг шинэ шатанд гаргана.

3.14. Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхит болон химийн бодисын хор нөлөөг багасгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. Хор хөнөөлтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагын ажлыг тухайн багийн оршин суугч иргэдийн оролцоо, хяналтын дор зогсоох, хязгаарлах арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

#### **ДӨРӨВ. АЖИЛСАГ, БҮТЭЭЛЧ ЧОЙБАЛСАН**

4.1. Хэрлэн гол дээгүүр гүүр барьж голын урд “ШИНЭ-НОГООН ЧОЙБАЛСАН” шинэ суурьшлын бүс байгуулна.

4.2. Чойбалсан хотын гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлж иргэдийн ая тухтай шинэ амьдралын хэв маягийг бий болгоно.


4.3. Чойбалсан хотын хатуу хучилттай авто замыг бүрэн шинэчлэн засварлана.

4.4. Амины орон сууцны хотхон, хороолол барьж байгуулах Засгийн газрын хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлнэ.

4.5. Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.6. Чойбалсан хотод дугуйн замын сүлжээг бий болгоно.

4.7. Сэргээгдэх эрчим хүчний талаарх гадны шинэ технологийг нэвтрүүлнэ.




- 4.8. Чойбалсан хотын гэр хороололын захын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг шинээр төлөвлөж хүчдлийн уналтыг арилгах ачаалалын зохицуулалт хийж, чадлын алдагдал багатай трансформатороор тоноглоно.
- 4.9. Чойбалсан хотын цахилгаан шугам сүлжээг 35кВ-ын гадна цагираг схемээр тэжээж хотын захаар үйлдвэрлэл хөгжих боломжтой цахилгаан хангамжийн найдвартай алдагдалгүй систем үүсгэнэ.
- 4.10. Чойбалсан хотын дулаан хангамжийн багтаамж 2 дахин өссөнтэй холбоотойгоор дулааны шугам сүлжээг өргөтгөн төвлөрсөн дулаан хангамжид хэрэглэгчдийг холбох
- 4.11. Багуудад нүхэн жорлон яндангүй инженерийн шугам сүлжээнд холбогдсон шинэ хороололыг бүтээн байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 4.12. Багуудад хэсэгчилсэн дахин төлөвлөлтийг Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шат дараатай хийнэ.
- 4.13. Ивээл хороололд дахин төлөвлөлтийг эхлүүлнэ.
- 4.14. Чойбалсан-Өндөрхаан Багануурын 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 дэд станцын барилга угсралтын ажлыг ашиглалтанд оруулж 86МВт Дулааны цахилгаан станцыг Төвийн эрчим хүчний системтэй холбож бүс нутгийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг нь дээшлүүлнэ.
- 4.15. Чойбалсангийн Дулааны цахилгаан станцыг 50МВт-аар өргөтгөх ажлыг эхлүүлнэ.
- 4.16. Чойбалсан – Баруун-Уртыг холбох босоо чиглэлийн 201 км авто зам;  
Чойбалсан – Баянхошуу 160 км авто зам;  
Чойбалсан – Хавирга 125 км авто замыг ашиглан “Зам дагасан хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ
- 4.17. “Нарны дээвэр” төслийг олон улсын байгууллагууд болон банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ
- 4.18. Мэдээлэл холбооны 5G технологи Чойбалсан хотод нэвтрүүлнэ
- 4.19. Чойбалсан хотод төмөр замын дэд бүтцийг түшиглэн төмөр замын логистикийн төв байгуулна.
- 4.20. Аймгийн төвд үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг хийж хэрэгжүүлнэ.
- 4.21. Хотын өнгө зүс, соёлд таагүй нөлөөтэй, олон жил ашиглахгүй удсан, муудсан барилга байгууламжийг эдийн засгийн эргэлтэд оруулж, өнгөлөг орчин бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 4.22. Газар зохион байгуулалтын асуудлыг ил тод зөв хэрэгжүүлэхэд анхаарч, шинээр олгогдох иргэдийн 0,7 га газруудын дэд бүтцийг зөв сайн төлөвлөн ажиллана.
- 4.23. Хотын төвийн зам, нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг хариуцсан нэгжийг бий болгон хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ.
- 4.24. Чойбалсан хотын орон сууцны байруудын засвар, үйлчилгээ, тохижилтын зардлын “Орон сууц хөгжлийн сан”-г бий болгож орон сууцанд амьдардаг иргэдийн ая тухтай, аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

ТАВ. АВЛИГАГҮЙ, АРДЧИЛСАН ЧОЙБАЛСАН

211714485  
ХТҮ4-07 0030081

- 5.1. Нутгийн удирдлагын шийдвэрийг ил тод шилэн болгоно.
- 5.2. Хууль зүйн туслалцааны төвийг бий болгон иргэдийн эрх зүй, хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлнэ.
- 5.3. Төрөөр бизнес хийдэг бүлэглэлийн хуйвалдааныг илчлэн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг, завшдаг явдлыг зогсооно.
- 5.4. Хариуцлагатай уул уурхайн бодлогыг хэрэгжүүлж, байгаль орчин түүний нөхөн сэргээлт, үр өгөөжийг орон нутгийн хөгжил дэвшилд хүртээмжтэйгээр зориулах ажлыг хэвшил болгоно.
- 5.5. Иргэдийн санал санаачлагад тулгуурласан хүний аюулгүй, ая тухтай амьдрахад чиглэсэн эрчимтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.6. Нийтийн эрх ашигт чиглэсэн шийдвэрийг гаргахдаа заавал Чойбалсан хотын иргэдийн саналыг авсны даргаа гаргадаг журмыг мөрдүүлнэ.
- 5.7. Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэдэг, иргэнийхээ төлөө үйлчилдэг “Хүний төлөө алба”-ыг ажиллуулна. Иргэдийн өргөдөл, гомдлын хариуг шуурхай шийдвэрлэж эзэнд нь заавал хүргэдэг журмыг хэрэгжүүлнэ.
- 5.8. Баг бүрийг өөрийн гэсэн төсөвтэй болгоно. Иргэдэд багийнхаа төсвийг юунд зарцуулахаа хэлэлцэж шийдвэрлэдэг эрхийг өгнө.
- 5.9. Орон нутгийн төсвийг төлөвлөх, санаачлах, батлах, зарцуулах, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, саналыг авдаг, хянадаг тогтолцоог бий болгоно.
- 5.10. Чойбалсан хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бүх байгууллагууд үйл ажиллагаагаа, гаргаж байгаа шийдвэрээ иргэдэд нээлттэй байлгадаг журмыг мөрдүүлнэ.
- 5.11. Авилга, хүнд суртал, ашиг сонирхолын зөрчилтэй хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргана.
- 5.12. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлнэ.
- 5.13. Нутгийн удирдлагад шууд ардчиллын зарчмыг нэвтрүүлэн удирдлагын тогтолцоог сайжруулна.
- 5.14. Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг ил тод болгоно. Хуралд иргэдийг нээлттэй оролцуулж олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд, шуурхай мэдээлж хэвшүүлнэ.
- 5.15. Иргэдийнхээ дуу хоолой болох, эрх ашгийг хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлсэн, хууль зөрчсөн ИТХ-ын төлөөлөгчдийг эргүүлэн татах, хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бий болгоно.



5.16. Төсөл, тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй, шударга явуулан тендерийн гүйцэтгэлийн хяналтыг сайжруулж, үр өгөөжийг дээшлүүлнэ. Тендерийн булхай, хуйвалдааныг зогсооно.

5.17. Төрийн болон нийтийн албанд ажиллах иргэдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод, шударга болгоно.

5.18. Шинээр ашиглалтанд орж буй орон сууц, барилга, байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, гэрэлтүүлэг, автомашины зогсоол, ногоон байгууламжийг шийдвэрлэснийг харгалзан ашиглалтанд хүлээн авдаг журмыг тогтоож хэрэгжүүлнэ.

### ЗУРГАА. АРД ИРГЭДДЭЭ ЭЭЛТЭЙ ЧОЙБАЛСАН

- 6.1. Баялаг бүтээгчдээ дэмжиж, Хэрлэн сумын иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана
- 6.2. “Өрх бүр баялаг бүтээгч” үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.3. Бизнес хөгжүүлэх төвөөр дамжуулан бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
- 6.4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.
- 6.5. Иргэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх хөтөлбөр хэрэгжүүлж, 7 хоногийн цалингийн системийн зарчмаар төгсөгчдийг өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- 6.6. Дэлхийн томоохон их сургуулийн хөтөлбөрөөр академик англи хэлийг богино хугацаанд эрчимтэй сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.7. Залуучуудын хөгжлийн “Community center” байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.
- 6.8. Гэр бүлийн гишүүн бүрт гэр бүлийн боловсрол олгох “Монгол гэр бүл” боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжиж ажиллана.
- 6.9. Ажил, хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ өргөжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 6.10. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар алслагдсан бүс нутагт дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх “Ахмад мэргэжилтний алба” ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.
- 6.11. Ахмад настуудын сургалтын төв байгуулж, дахин ур чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.12. Ахмадын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулна.
- 6.13. Ахмад настанд зориулсан бүсчилсэн сэргээн засах, эмчилгээ, сувилгааны цогцолбор төвийг байгуулахад, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 6.14. Өрх толгойлсон эх, эсвэл эцэгт хүүхдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөл бүхий тэтгэлэг олгох тогтолцоо, богиносгосон ажлын цагийн хуваарийг мөрдөх боломж бүрдүүлнэ.
- 6.15. Барилгын салбарт ажиллагсдын эрүүл мэндийн болон санхүүгийн эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллана
- 6.16. Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна

- 6.17. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвийг улам хөгжүүлж ажиллана.
- 6.18. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.
- 6.19. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.
- 6.20. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандарт хэрэгжүүлнэ.
- 6.21. Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 6.22. Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар баг бүрт бага насны хүүхэд нэг км радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжийг бүрдүүлнэ.
- 6.23. Өрх, багт үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих “эрүүл, чийрэг хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.24. ЕБС-ийг нэг ээлжээр сурах боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 6.25. Хэрлэн суманд сургуулийн автобусаар үйлчилж, хүүхэд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.26. Хэрлэн сумын төвд аливаа хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах хууль, журмыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран, тогтмол хэрэгжүүлнэ.
- 6.27. Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхэний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.
- 6.28. Хүүхдийг цахим дарамт, мөлжлөг, зохисгүй контент зэрэг цахим гэмт хэрэг, аюулаас хамгаалах үйл ажиллагаа, оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулна.
- 6.29. Оюутны дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- 6.30. Гадаадад суралцаж, ажиллаж байгаа болон орон нутагтаа эргэн ирж буй залуучуудад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.31. Гадаадад ажиллаж байгаа иргэдийнхээ мэргэшсэн байдлыг харгалзан өөрийн туршлага, шинэ мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нутагтаа нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 6.32. Чойбалсан хотын гэр хорооллын иргэдийг хувийн орон сууцтай болгох чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.
- 6.33. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтэцэд бүрэн холбогдсон амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 6.34. ЕБС-ын бага боловсрол эзэмшиж буй хүүхдүүдэд “Сүү” хөтөлбөр хэрэгжүүлж, сурагчдын үдийн хоолны төсвийг нэмэгдүүлнэ.
- 6.35. Зуны цэцэрлэг, хөдөлмөр амралтын зусланг бий болгох санаачилгыг дэмжиж ажиллана.
- 6.36. “Залуу гэр бүл” -ээ дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.37. “Ахмад настны хөгжил, хамгаалал” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.38. Багуудын газар тариалан эрхэлдэг өрх, иргэдийг бодлогоор дэмжинэ
- 6.39. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвийн үйл ажиллагаанд орон нутгийн бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- 6.40. Алслагдсан багуудад хүүхдийн, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулна.

